

Хосмог сургалт, хөдөлмөр эрхлэлт, суралцагчийн хөгжлийн асуудал хариуцсан шинжээч, Энхболд Эрдэнэбилэг

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах							
1	Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, их сургуулийн хотхоны дахин төлөвлөлт хийгдэж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулж батлуулна.	Дүрэм, журамд хотхон зохион байгуулалттай холбоотой удирдлага, бүтцийн зохион байгуулалтын талаар тусгасан байна.	-	Дүрэм, журамд хотхон зохион байгуулалттай холбоотой удирдлага, бүтцийн зохион байгуулалтын талаар тусгасан байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/280 дугаар тушаалаар батлагдсан 2023-2024 оны хичээлийн жилд шинээр элсэн суралцах элсэлтийн хяналтыг тоог Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 306 дугаар тогтоол “Төрийн өмчийн их сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай”; Монгол Улсын Засгийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 27 дугаар тогтоол “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”; Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/11 дүгээр тушаал “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/12 дугаар тушаал "Журам батлах тухай"- зэрэг тушаал шийдвэрийн дагуу дахин шинэчлэн боловсруулсан. Ингээд дээрх эрх зүйн үндэслэлийн дагуу 2023-2024 оны хичээлийн жилийн элсэлтийн хяналтын тоог БШУ-ы сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/95 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Мөн 2024-2025 оны хичээлийн жилийн элсэлтийн хяналтын тооны саналыг дээрх дүрэм, журмын дагуу боловсруулж		
--	--	--	--	--	--	--	--

					мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөж байна. Сургалтын байгууллагууд элсэлтийн хяналтын тоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, бүс орон нутгийн хөгжил, сургалтын байгууллагын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж шинэчлэн байгуулагдсан Удирдах зөвлөлийн анхдугаар хуралдаанаараа хэлэлцүүлэн батлуулж ирүүлээд байна.		
1.2. Боловсрол, шинжлэх ухааны хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах							
2	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан журам, дүрэм, стандартыг боловсруулж, батлуулна.	Дүрэм, журмыг боловсруулж батлуулсан байна. Дүрэм журмын тоо	Журам-3	Дүрэм, журам-5	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан "Чадамжийн төв, дадлагын баазад тавих нийтлэг шаардлага", "Сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загвар", "Эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлийн жагсаалт батлах", "Хосмог сургалтын журам", "Хосмог сургалтын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					менежментийн хорооны үйл ажиллагааны дүрэм" зэрэг дүрэм, журмын төслийг газрын түвшинд 4 удаа, Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран 1 удаа хэлэлцүүлж, хамтран боловсруулахад чиг үүргийн дагуу оролцсон. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд салбарын зүгээс тусгах санал буюу өөрчлөн найруулах заалтуудын саналыг боловсруулж Тэгш хамран сургах бодлогын хэлтэст хүргүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хөгжлийн төвийн бүтэц, чиг үүргийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, хурлын багийн ажил, хэлэлцүүлэгт оролцсон.		
1.3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ							
3	Бүх түвшний сургалтын хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх, шударга, ёс зүйтэй иргэнийг	Сургалтын хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх, шударга, ёс зүйтэй иргэнийг төлөвшүүлэх	Сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулагдсан	Сургалтын хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх, шударга, ёс зүйтэй иргэнийг төлөвшүүлэх агуулгыг судалж боловсруулна.	Сургалтын байгууллагын багш, ажилтан, албан хаагч ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн

	төлөвшүүлэх агуулгыг тусгаж, соён гэгээрүүлэх арга хэмжээ авч ажиллана.	агуулгыг тусгасан байна.			соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, сургалтын хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх, шударга, ёс зүйтэй иргэнийг төлөвшүүлэх агуулгыг тусгаж, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж байна. Сургалтын байгууллагууд ЕБС-ийн ахлах ангийн суралцагчид, эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийт, түншлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад мэргэжил сурталчлах, сургалтын хөтөлбөрөө танилцуулах "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг жил бүр тогтмол зохион байгуулж ирсэн. Тус өдөрлөгөөр сургалтын байгууллагууд сургалтын хөтөлбөрийн онцлог, түншлэгч аж ахуйн нэгжтэй хэрхэн хамтран ажиллаж буй давуу тал, сургалтын байгууллагын онцлогоо танилцуулдаг бөгөөд энэ хүрээнд оюутан суралцагчдыг соён гэгээрүүлэх авлигаас урьдчилан сэргийлэх, шударга, ёс зүйг эрхэмлэх чиглэлээр	сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	--------------------------	--	--	---	-----------------------------------	--

					нөлөөллийн олон талт үйл ажиллагааг зохион байгуулж байна.		
3.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хөгжил, сургалтын чанар, багш, суралцагчийн хөгжил, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг боловсронгуй болгох удирдлага, зохион байгуулалтаар хангах							
4	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын элсэлт, төгсөлт, элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал батлах тухай журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	Сайдын тушаалаар батлагдсан байна.	Сайдын тушаалаар батлагдсан.	Журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Мэргэжлийн болон техникийн боловсролын 69 сургалтын байгууллагын 2024-2025 оны хичээлийн жилийн элсэлтийн хяналтын тооны саналыг БШУС-ын 2024 оны А/12 тоот тушаалын дагуу боловсруулж байна. Элсэлтийн хяналтын тоог боловсруулахдаа журамд заасны дагуу нийт 69 сургалтын байгууллагуудаас Тоон болон чанарын аргачлалын дагуу хийсэн үнэлгээний үр дүн, хураангуй тайлан, Элсэлтийн хяналтын тооны саналыг удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн протокол, шийдвэр, Сургалтын байгууллагын албан хүсэлт зэргийг авч, холбогдох материалыг судлан, дүн шинжилгээ хийж байна. Мөн 69 сургалтын байгууллагын өнгөрсөн хичээлийн	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					жилийн элсэлтийн статистик тоон мэдээг мэргэжил тус бүрээр нягтлан судалж, энэ хичээлийн жилийн саналтай харьцуулсан судалгаа хийж боловсруулж байна. Өнгөрсөн хичээлийн жилийн элсэлтийг тооцохдоо мэргэжлийн чиглэл индексийг шинэчлэн баталсан тушаалын дагуу мэргэжил тус бүрийн шинэ, хуучин индекст тулгалт хийсэн. Элсэлтийн хяналтын тоог Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын зөвлөлөөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлын хүрээнд элсэлтийн хяналтын тоог хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулсан байдал, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, эрэлттэй мэргэжлийн чиглэл, сургалтын байгууллагын элсэлт төгсөлтийн статистик мэдээ зэрэг агуулгын хүрээнд ppt танилцуулгыг бэлтгэж байна. Газрын даргын		
--	--	--	--	--	--	--	--

					зүгээс элсэлтийн хяналтын тоо боловсруулах чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, сургалтын байгууллагын удирдлагуудтай холбогдож элсэлтийн квотын боловсруулалтыг сайжруулах, салбарын бодлого, олон улсын төсөл хөтөлбөртэй уялдуулах, элсэлт төгсөлтийн статистиктай харьцуулах талаар үүрэг чиглэл өгч ажиллаж байна.		
5	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид олгох боловсролын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх, олгох журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	Журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Сайдын тушаалаар батлагдсан.	Журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2024-2025 оны элсэлтийн хяналтын тоог боловсруулахтай холбоотой сургалтын байгууллагын удирдлагуудыг "Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид олгох боловсролын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх, олгох" БШУС-ын 2024 оны А/13 дугаар шинэчилсэн журмын талаар мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллаж	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байна. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид олгох боловсролын баримт бичгийг мэдээллийн санд бүртгэх, баталгаажуулах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх уулзалтыг Боловсролын мэдээллийн технологийн төв, Боловсролын ерөнхий газартай хамтарсан уулзалтыг удаа дараа, тогтмол хийж байна.		
6	Хосмог сургалт, ажлын байран дахь сургалт зохион байгуулах журмыг боловсруулж батлуулна.	Сайдын тушаалаар батлагдсан байна.	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулиар шинээр тусгагдсан заалт	Журмын төсөл боловсруулагдсан байна.	Хосмог сургалт, ажлын байран дахь сургалтыг нэвтрүүлэх зорилгоор БШУЯ болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын хооронд 2024 оны 03 сарын 18-нд байгуулсан санамж бичгийн дагуу “Мэргэжлийн болон техникийн боловсролын хосмог тогтолцоог хөгжүүлэхтэй холбоотой талуудын оролцоог тодорхойлох, менежментийн хорооны үйл ажиллагааны чиглэл, бүтэц бүрэлдэхүүнийг зөвшилцөх, дүрмийн	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					төсөл танилцуулах” зорилготой зөвлөлдөх уулзалтыг 2024 оны 05 сарын 16, 05 сарын 31-ний өдрүүдэд зохион байгуулсан. Уулзалтад Боловсрол, шинжлэх ухааны яамны БНБТГ-ын дарга П.Оюунаа, Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга А.Халиунаа тэргүүтэй 4 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн тахимын ерөнхийлөгч Д.Энхтүвшин тэргүүтэй 2 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн захирал Juergen Hartwig тэргүүтэй 4 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл, ажил олгогч ААН-ийн төлөөлөл, зөвлөх үйлчилгээ үзүүлж буй “Скиллстек” компаний захирал Д.Энхжаргал тэргүүтэй 2 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл бүхий нийт 15 төлөөлөл оролцлоо. Уулзалтын үр дүнд менежментийн хорооны бүтэц бүрэлдэхүүн, үйл	
--	--	--	--	--	--	--

					ажиллагааны дүрмийн төслийг хэлэлцэн санал солилцсон бөгөөд талуудын дэвшүүлсэн санал, зөвлөмжийг тусган боловсруулж БШУ-ны сайдад тушаалын төслийг танилцуулж батлуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү менежментийн хороо нь дүрэмд заасны дагуу ажлын албатай байх бөгөөд ажлын алба нь менежментийн хорооны удирдлага дор хосмог сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж, журам, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийн дагуу ажиллах юм. Мөн хосмог сургалтын журмын төслийн танилцуулах уулзалтыг 06 сарын 05-нд БШУЯ, ХНХЯ, БЕГ, Сургалтын байгууллага, ААН байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан		
--	--	--	--	--	---	--	--

					бөгөөд журмын төслийг хэлэлцүүлж, талуудын саналыг нэгтгэн боловсруулж байна. Хавсралт: 6 файл		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр бие даан судалгаа шинжилгээ хийсэн байна.	Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, тэдгээрийн хүрээнд шинээр батлагдсан дүрэм, журмыг судлана.	Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, тэдгээрийн хүрээнд шинээр батлагдсан дүрэм, журмыг үе шаттай судалсан	Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, тэдгээрийн хүрээнд шинээр батлагдсан дүрэм, журмыг судлана.	Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон холбогдон гарсан дүрэм, журам, загвар, аргачлалыг судлан, мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Тухайн сард боловсруулсан тушаал шийдвэр, албан бичиг зэрэг өдөр тутмын ажил үүрэгтэй холбоотой хуулийн заалт, дүрэм журмыг мөрдөж	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					ажилласан. Мөн сургалтын байгууллагуудтай танилцаж, ажлын чиг үүргийн дагуу уулзалт, арга хэмжээнд оролцсоноор салбарын үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй болж мэдлэг чадвараа дээшлүүлэх боломж бүрдсэн. Мөн Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн цагуудад оролцож "Албан хаагчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн үндэс: стресс менежмент", "Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал" зэрэг сэдвүүдээр мэдээлэл сонсож, мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Мөн Төрийн захиргааны удирдлагын газрын даргын зүгээс мэдээллийн цагт танилцуулсан байгууллагын дотоод зохион байгуулалттай холбоотой мэдээлэл авсан. Мөн Төрийн албаны бичиг хэргийг хос бичгээр явуулахтай холбогдуулан монгол бичгийн мэдлэг чадвараа бие даан хөгжүүлж байна.		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хосмог сургалт, хөдөлмөр эрхлэлт, суралцагчийн хөгжлийн асуудал хариуцсан шинжээч, Энхболд Эрдэнэбилэг
/...../ Огноо: